



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 08 дугаар сарын 12 өдөр

Дугаар 74

Хэрлэн сум

LXXIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 74 дүгээр хуралдаан 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 09:00 цагт танхимаар 65,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн сурын холбооноос аймгийн Засаг даргад ирүүлсэн албан хүсэлтийг хэлэлцэж, аймгийн Үндэсний сурын харвааг зохион байгуулах талаар холбогдох шийдвэр гаргах,

*АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс*

2.Үндэсний сурын харваа зохион байгуулах тухай тогтоол, түр журмын төслийг танилцуулах,

*АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс*

3.Аймгийн сурын холбоотой хариуцлагын гэрээ байгуулах төслийг танилцуулах,

*АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс*

4.Диско баар, караокены үйл ажиллагааг нээх эсэх талаар хэлэлцэх,

*Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТХэлтэс,  
Мэргэжлийн хяналтын газар*



5.Хөлөнбуйр, Баянтүмэн, Ялалт, Модон гүүрийн хяналтын цэгийн 2021 оны 08 дугаар сарын 01-31-ны өдрүүдийн шатахуун, хоол, хувийн хамгаалах хэрэгслийн зардлын тооцоог хэлэлцэх,

*АЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс,  
Эрүүл мэндийн газар*

6.Тусгаарлан ажиглах байрны зориулалтаар ашиглаж буй "Сод", "Дулаан" буудлуудын үйл ажиллагааны зардлын тооцоог танилцуулж шийдвэрлүүлэх,

*Эрүүл мэндийн газар, Ерөнхий тархвар судлаач Б.Ганганцэцэг*

7.Ачаа, тээврийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг цаашид үргэжлүүлэх эсэх талаар,

/  / М.Бадамсүрэн  
/  / Х/ч Б.Цогтбаяр

Авто тээврийн төв,  
8.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн  
албан бичиг, хүсэлт танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Б.Чимэддорж,  
Аймгийн Сурын холбооны тэргүүн Л.Баттулга нарт:

- 1.1.Аймгийн Үндэсний сурын харвааг зохион байгуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж баталгаажуулахыг,
- 1.2.Үндэсний сурын харвааг 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс 15-ны өдрүүдэд аймгийн сур харвааны талбайд үзэгчгүйгээр, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн зохион байгуулахыг,



Хоёр. АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Аймгийн Ерөнхий тархвар судлаач Б.Ганганцэцэг,  
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,  
Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Н.Энхболд нарт:

- 2.1.Аймгийн хэмжээнд Диско баар, караоке баарны үйл ажиллагааг нээх эсэх талаар тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн удирдлагыг байлцуулан хэлэлцүүлгийг 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулах,
- 2.2.Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг диско баар, караоке бааруудад хяналт шалгалтыг зохион байгуулах,
- 2.3.Диско баар, караоке бааранд хийсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэн аймгийн Онцгой комиссын 75 дугаар хуралдаанаар танилцуулах,

Гурав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт,

- 3.1.Баянтүмэнгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгт Цагдаагийн газраас өдөр бүр алба хаагч ажиллуулж, Ялалт, Модон гүүрний шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд олон нийтийн байцаагчаас бусад алба хаагч нарыг 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн буулгахыг,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт

/  / М.Бадамсүрэн  
/  / Х/ч Б.Цогтбаяр

3.2. Ялалт, Модон гүүрийн хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг буулгасантай холбогдуулан Хөлөнбуйр болон бусад хяналтын цэгийн шатахуун, хоол, хувийн хамгаалах хэрэгслийн зардлын тооцоог дахин гаргаж аймгийн Онцгой комиссын 75 дугаар хуралдаанд танилцуулахыг,

Дөрөв. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1. Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт нүүрний хаалт 200 ширхэг, нэг удаагийн амны хаалт 5115 ширхэг, шүүлтүүртэй амны хаалт 248 ширхэг, комбинзон 186 ширхэг, улавч №50-4 ширхэг, малгай №50-6 ширхэгийг аймгийн Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Эрүүл мэндийн газарт олгохыг,

4.2. Хүний эрхийн Үндэсний комиссын Дорнод аймаг дахь төлөөлөгч н.Дугарсүрэнг аймгийн Онцгой комиссын хуралдаанд оролцуулж байхыг,

Дөрөв. Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт

4.1. "Дулаан" буудалд иргэдийг тусгаарлахад гарсан 6,757,708 төгрөгийн зардлыг тооцож, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх, цаашид татан буулгах,

4.2. "Сод" буудалд иргэдийг тусгаарлахад гарсан 7,575,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Тав. Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр-д:

5.1. Ачаа, тээврийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийн саналыг үндэслэн халдвар голомтлон тархсан бүс нутгаас ирсэн ачаа тээвэрт хяналт тавих ажлын хэсгийг 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс татан буулгах


Зургаа. Онцгой комиссын гишүүдэд

6.2. Хүний эрхийг хангах чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтлан шийдвэр гаргаж байх,

Долоо. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч, хошууч Б.Цогтбаяр-т:

7.1. "Петрочайна Дачин тамсаг" ХХК-ийн хүсэлтээр Монгол Улсад хөдөлмөр эрхлэх БНХАУ-ын 7 ажилтныг холбогдох журмын дагуу Улаанбаатар хотод 14 хоногийн тусгаарлан ажиглах хугацаа дууссаны дараа дахин аймгийн Онцгой комисст хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх талаар албан бичиг хүргүүлэх,

Найм. Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр, Эрүүл мэндийн газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

 / М.Бадамсүрэн  
/ Х/ч Б.Цогтбаяр

Мэргэжлийн хяналтын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

8.1.Хот хоорондын нийтийн тээврийн автобусанд 30-аас илүүгүй зорчигчтойгоор Улаанбаатар-Чойбалсан, Чойбалсан-Улаанбаатар чиглэлд 7 хоногийн өдөр бүр автобусны тоог хязгаарлахгүйгээр дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан иргэнийг зорчуулах,

8.2.Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

ДАРГА



М.БАДАМСҮРЭН

/ ~~М.Бадамсүрэн~~ / М.Бадамсүрэн  
/ ~~Х/ч Б.Цогтбаяр~~ / Х/ч Б.Цогтбаяр